

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024.07.05

Алтай хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго: Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй: Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг удирдлага болгож, хэрэгжилтийн үнэлгээ хийлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

1. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилгын 27 зорилтын хүрээнд 156 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- ❖ Бодлогын баримт бичигт тусгагдсан 7 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ,
- ❖ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхээр 8 зорилтын хүрээнд 77 арга хэмжээ,

- ❖ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр 8 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ,
- ❖ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ байна.

3. 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 156 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 59 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 18 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 29 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 21 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 21 арга хэмжээ, 0 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ нийт 72 хувийн хэрэгжилттэй байна.

4. Эрчимжүүлэх шаардлагатай 50 арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээний дугаар, агуулга	Хэрэгжилтийн хувь	Хариуцах хэлтэс, агентлаг
50 хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүд			
1	Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор булаг шандны эхийг хашиж хамгаалах;	50%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
2	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нээлттэй-Алтай" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	50%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
3	Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлийг бага түвшинд хүргэх	50%	Санхүү төрийн сангийн хэлтэс
4	Аялал жуулчлалыг хөгжүүлэх эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дэмжин ажиллах;	50%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
5	Татан буугдаж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын татан буулгах ажиллагааг дуусгаж, тайлагнах;	50%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
6	"Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
7	Хүн амын нас, хүйс, эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан багцын эрт илрүүлэг, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй зохион байгуулах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
8	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
9	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд" арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх ялангуяа сумын эрүүл мэндийн төвд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн амны хөндийн үзлэг оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
10	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд нь дэмжлэг	50%	Нийгмийн бодлогын хэлтэс

	үзүүлэх биеийн тамир, спортын барилга байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, хүртээмжтэй болгох, клубын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх;		
11	Өсвөр үеийн шигшээ багийг 8 (найм)-аас доошгүй төрлөөр байгуулж, тамирчдын бэлтгэлийг ханган наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах зардлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
12	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогоох сорил"-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж иргэдийг хамруулах, шинэ тоголцоог бий болгоход хамтран ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
13	ЭЕШ-д бэлтгэл ажлын хүрээнд нэгдсэн болон судлагдахуун бүрээр олимпиад, сорилго шалгалтыг зохион байгуулж, ментор багш нарын баг ажиллуулан давтлага өгч ЭЕШ-ын дундаж оноог нэмэгдүүлэх;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
14	Аймгийн хэмжээнд үндэсний хэл, бичиг үсгээ сурч судлах, эзэмших, хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
15	Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
16	"Соёлын сэргэлт-2024" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
17	"Go Mongolia" аяны хүрээнд Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн брэнд соёл, урлагийн наадмын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
18	Орон нутгийн хөгжлийн талаар шийдвэр гаргах түвшинд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүдийн бодит оролцоог хангаж ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
19	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын аюулгүй байдлыг хангаж, түр хамгаалах байрны санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган, үйлчилгээ үзүүлэхдээ тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, иргэд, олон нийтийн санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
20	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийг хэрэгжүүлж ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
21	Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах;	50%	Нийгмийн бодлогын хэлтэс
30 хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүд			
22	Сумдын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
23	Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

24	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах ;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
25	"150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд эрүүл мэнд, нийгмийн салбар, төрийн захиргааны болон бусад төрийн албан хаагчдыг орон сууцаар болон түрээсийн орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
26	Аймгийн төвийн 10 км хатуу барих ажлыг үргэлжлүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
27	Аймгийн төвд шинээр 15.6 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
28	Ентүм зочид буудлаас 3,4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг Хөгжил хорооллын доод талаас 3,4 дүгээр хорооллын гудамжны хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
29	Дэлгэр, Шарга сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбох ажлыг эхлүүлэх;	30%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
30	Шинжлэх ухааны чиглэлээр гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгасан холбогдох заалтыг хэрэгжүүлж тайлагнах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
31	"Авьяаслаг Алтайчууд" арга хэмжээг АДБАЧ-тай хамтран зохион байгуулах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
32	Уламжлалт өв соёлыг тээгчид ардын авьяастнуудыг дэмжих, сурталчлах, бүтээл урлалыг өвлөн уламжлах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
33	"Засагт ханы хот айл гэр зуслан"-г 5-аас доошгүй сумдад байгуулан монгол ахуй, ёс заншил, амьдрах ухаанд суралцуулах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
34	"Жангар фесиваль"-ийг зохион байгуулах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
35	Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зорилготой "Түр хамгаалах байр"-г Япон улсын "Өвсний үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр байгуулж, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
36	Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах-1111 төвөөс шилжин ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг эрс сайжруулж, хугацааг 2 дахин бууруулах ;	30%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
37	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 20.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах, цалингийн зардлын тооцоог төсвийн тодотголд тусган батлуулах, хуулинд заасан албан тушаалтнуудыг гэрээгээр авч ажиллуулах;	30%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

38	Төрийн архивын барилгыг ашиглалтад орсонтой холбогдуулан ашиглагдах тоног төхөөрөмжийг шинэчлэн нэмэгдүүлэх;	30%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
39	“Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах;	30%	Цэргийн штаб
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хангах хүрээнд сонгуулийн санал авах байрыг хүртээмжтэй болгох, тэдний улс төрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
41	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг саадгүй, хүртээмжтэй авах нөхцөл боломжийг бүрдүүлж, иргэдийн хамгийн их ашигладаг болон аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсуудын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулан, орон нутгийн телевизийн хөтөлбөрийг хадмал орчуулагчтайгаар гаргах, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар нийгэмд чиглэсэн мэдээ мэдээлэл, хуулийн хэрэгжилтийг сурталчлахад анхаарч үнэ төлбөргүй түгээх;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
42	Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, нийтийн тээвэр, зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг бүхий л хүнд хүртээмжтэй болгох хөтөлбөрийг батлан, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;	30%	Нийгмийн бодлогын хэлтэс
0 хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүд			
43	Шинээр гэр бүл болсон малчин залуусыг малжуулах ажлыг зохион байгуулах;	0%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
44	Ижил агуулгын хүрээнд ихээр өргөдөл, гомдол ирж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн шуурхай арга хэмжээ авах ;	0%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
45	“Иргэдийн спортын наадам-2024” арга хэмжээг зохион байгуулах;	0%	Нийгмийн бодлогын хэлтэс
46	“Багш- Эрдэнэ” арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулах;	0%	Нийгмийн бодлогын хэлтэс
47	Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх асуудлаар хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, шинэ санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллах;	0%	Нийгмийн бодлогын хэлтэс
48	Хөмрөг үүсгэгч байгууллагын архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийх, цахим хэлбэрт шилжүүлэх, шаардлагатай зардлыг шийдвэрлэх	0%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
49	Архивын баримтыг хүлээн авах хуулийн хугацаа болсон байгууллагуудын баримтыг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулах;	0%	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
50	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын бэлэн байдлыг хангах;	0%	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн 156 арга хэмжээний дундаж үнэлгээгээр нийт 72 хувийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.

2. Эрчимжүүлэх шаардлагатай 50 арга хэмжээ байна. Үүнээс: Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хамааралтай 14 арга хэмжээ, Нийгмийн бодлогын хэлтэст хамааралтай 28 арга хэмжээ, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хамааралтай 6 арга хэмжээ, Санхүү төрийн сангийн хэлтэст хамааралтай 1 арга хэмжээ, Цэргийн штабын 1 арга хэмжээ байна.

ДӨРӨВ: ЗӨВЛӨМЖ

Хэлтсийн дарга нарт:

1. Хэрэгжилтийг тайлагнахдаа 2000 тэмдэгтэд багтааж, арга хэмжээний явцыг бус хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлттэй уялдуулан тайлагнаж хэвших.

2. Эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ахиулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

